

ӨГҮҮЛЭЛ

**БНХАУ-ын шинэ таван жилийн төлөвлөгөө,
эдийн засгийн бодлогын өөрчлөлт****Мөнхөөгийн Эрдэнэбаяр**

Доктор Ph.D, эрдэм шинжилгээний ажилтан,
ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, Улаанбаатар, Монгол Улс
erdenebayar_m@mas.ac.mn

Хураангуй: БНХАУ уламжлалт ёсоороо энэ оны 3 дугаар сард 2021-2025 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх XIV таван жилийн төлөвлөгөөгөө баталлаа. Уг төлөвлөгөө шинэтгэл, үйлдвэрлэл, технологи, аюулгүй байдлыг чухалчилж, мөн 2035 оныг хүртэлх урт хугацааны зорилтыг дэвшүүлснээрээ онцлог байна. Төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүлэх түлхүүр бодлого нь дотоодын зах зээлийг эрчимжүүлж эдийн засгийн өсөлтийн үндсэн хөдөлгөгч хүч болгох бөгөөд өрхүүдийн орлого хангалттай өндөр бус, нөөц ашиглалтын үр өгөөж тааруу, цар тахал, Хятад Америкийн сөргөлдөөн зэрэг багагүй сорилт тулгарч буй. Энэхүү өгүүллийн эхний хэсэгт Хятадын шинэ таван жилийн төлөвлөгөөний голлох зорилт, стратеги, онцлогийг дурдаж, хоёрдугаар хэсэгт тус улсын эдийн засгийн хөгжлийн бодлогод гарч буй өөрчлөлтөд дүн шинжилгээ хийн, гуравдугаар хэсэгт тулгарч буй сорилт, биелэгдэх боломжийн талаар авч үзэж, төгсгөлд нь Монгол Улсын эдийн засагт үзүүлж болох нөлөө, анхаарах асуудлын тухайд санал бодлоо хуваалцлаа.

Түлхүүр үг: XIV таван жилийн төлөвлөгөө, хос эргэлт стратеги, сорилт ба боломж, нөлөө



Монгол Улсын худалдаа, эдийн засгийн хамгийн том түнш БНХАУ-ын хөгжлийн бодлого, төлөвлөгөөг судлах, тэдний хаашаа зорьж, юу хүсэж буйг мэдэх нь бидний хувьд чухал. Тус улсын 2021 оны “Хоёр чуулган”¹ 3 дугаар сарын 4-11-ний өдрүүдэд чуулж, Засгийн газрын ажлын тайланг хэлэлцэн, үндэсний эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх XIV таван жилийн төлөвлөгөө (2021-2025)-г батлав. Уг төлөвлөгөөний саналыг 2020 оны 10 дугаар сард ХКН-ын XIX Төв хорооны V бүгд хурлаар өргөн барьсан ба тус нам байгуулагдсаны 100 жилийн ойгоор (1921-2021) “дунд зэргийн чинээлэг нийгмийг бүрэн байгуулах” улс төрийн чухал зорилгоо биелүүлсэн хэмээн зарласан. Хэдийгээр Хятадын XIII таван жилийн төлөвлөгөө (2016-2020)-нд тусгагдсан эдийн засгийн хэмжээг өсгөх, ажлын байр нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах зэрэг дийлэнх

зорилт биелэгдсэн² боловч ДНБ-ний өсөлтийн зорилт хангагдаагүй,³ үүнийг үндсэндээ дэлхий даяар тархсан цар тахалтай холбон тайлбарлаж буй. Шинэ таван жилийн төлөвлөгөө нь инновац, бүс нутгийн уялдаа холбоо, ногоон хөгжил, олон улсын нээлттэй байдал, нийгмийн тэгш байдал зэрэг өмнөх таван жилийн төлөвлөгөөний зарчим дээр суурилсан бөгөөд цар тахал, их гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөн зэрэг хүчин зүйлийг тооцож аюулгүй байдлыг хангах асуудлыг илүүтэй анхаарчээ.⁴ Ирэх таван жил нь тус улс байгуулагдсаны 100 жилийн ойгоор (1949-2049) “орчин үеийн чинээлэг, хүчирхэг социалист улсыг бүрэн байгуулах” дараагийн зорилгоо хэрэгжүүлж эхлэх түүхэн чухал үе бөгөөд 2035 оны урт хугацааны зорилт, XIV таван жилийн төлөвлөгөө нь дээрх “хэтийн зорилго”-д хүрэх дунд, богино хугацааны үндэсний хөгжлийн стратеги, үйл ажиллагаа нь болж байна.

-
- 1 Хоёр чуулган бол Хятадын Улс төрийн зөвлөлдөх зөвлөл, Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн Их хурал (БХАТИХ)-ын жил бүр зохион байгуулдаг хурал юм. Тус чуулганаар өнгөрсөн жилийн ажлын явцаа дүгнэн, ирэх жилүүдэд хэрэгжүүлэх томоохон бодлогуудаа зарладаг.
 - 2 Тус улс өнгөрсөн таван жилд ДНБ 70 их наяд юаниас 100 их наяд юань болон өссөн, 55.75 сая хөдөөгийн иргэдийг ядуурлаас ангижруулсан, хот суурин газруудад 60 сая гаруй ажлын байр шинээр бий болгосон зэрэг голлох амжилт гаргажээ. 2021年政府工作报告, http://www.gov.cn/premier/2021-03/12/content_5592671.htm; БНХАУ-ын Засгийн газрын ажлын тайлан 2021
 - 3 XIII таван жилийн хугацаанд ДНБ-ний жилийн өсөлтийг 6.5%-иас дээш байхаар зорилт тавьсан, харин 2019 онд 6.1%, 2020 онд 2.3%-ийн өсөлтийг үзүүлсэн.
 - 4 Өмнөх таван жилийн төлөвлөгөөнд “аюулгүй байдал” гэх үг 46 удаа давтагдаж байсан бол шинэ таван жилийн төлөвлөгөөнд 66 удаа, харин “үндэсний аюулгүй байдал” гэх үг 7-гоос 15 болж өсжээ.

Нэг. Шинэ таван жилийн төлөвлөгөөний голлох зорилт, стратеги

XIV таван жилийн төлөвлөгөө нь Хятадын дараагийн “хэтийн зорилго”-ыг эхлүүлж, энэ утгаараа 2035 оны урт хугацааны зорилтыг багтааж буй, өөрөөр хэлбэл, ирэх 30 жилийг 15 жилээр хуваан, явах замаа илүү тодорхой болгож байна. Тус улс 2035 он гэхэд “социалист модернизаци”-ийг бүрэн бий болгох, үүнд, шинжлэх ухаан, технологийн хүч чадлыг огцом өсгөх, эдийн засгийн нийт хэмжээ, нэг хүнд ногдох орлогоо дунд зэргийн хөгжингүй орнуудын түвшинд хүргэх,⁵ инновациар дэлхийн тэргүүлэгчдийн нэг болох зэрэг амбицтай зорилт дэвшүүлжээ.

Харин шинэ таван жилийн төлөвлөгөөний хугацаа (2021-2025)-нд ДНБ-ний өсөлтийн тодорхой тоон зорилт дэвшүүлээгүй бөгөөд жилийн дундаж өсөлтийг зохист хүрээнд барьж, өсөлтийн зорилтыг нөхцөл байдлыг харгалзан жил бүр тогтоох аж. Хөдөлмөрийн нийт бүтээмж ДНБ-ээс хурдацтай өснө. Үнийг тогтвортой байлгаж, хот суурин газрын ажилгүйдлийн түвшинг 5.5 хувиас доош барина. Дотоод зах зээлийг илүү хүчирхэг, эдийн засгийн бүтцийг илүү оновчтой болгох “Хос эргэлт стратеги” хэрэгжүүлнэ.⁶

Хөдөө аж ахуй, хөдөөг хөгжүүлэх зорилт тэргүүлэх ач холбогдолтой хэвээр байна. Тус улс газар нутагтайгаа харьцуулахад тариалангийн талбай хязгаарлагдмал тул хүнсний аюулгүй

байдал амин чухал, нөгөө талаас, метрополитан хотууд, түүнийг дагасан хот сууринг хөгжүүлэх замаар хотжилтыг нэмэгдүүлэх, хот хөдөөгийн харилцан нөхөн хөгжих чадавхийг сайжруулах аж. 2025 он гэхэд хотуудын байнгын оршин суугчдын хэмжээг 65%-д хүргэх, үүнийг хөдөө орон нутгаас шилжин ирэгсэдийн оршин суух эрхийг хурдан олгох замаар хэрэгжүүлнэ. Бүс нутгийн хөгжлийн томоохон стратегийг үргэлжлүүлнэ, үүнд, Бээжин-Тяньжин-Хөбэйн бүс, Хөх нуурын эдийн засгийн бүс, Гуандун-Хонконг-Макаогийн их эргийн бүс, Сюньганы шинэ бүс, Чэнду-Чунцинийн эдийн засгийн бүсийг хөгжүүлнэ.

Шинэтгэл, нээлттэй байдлыг улам ахиулах бөгөөд шинэтгэлийн цөм нь инновац байна. Судалгаа, шинжилгээнд зориулах зардлыг жилийн 7%-иас дээш өсгөхийг хичээнэ. Хиймэл оюун, квант тооцоолол, хагас дамжуулагч, мэдрэл судлал, ген ба биотехнологи, эмнэлзүй ба эрүүл мэндийн үйлчилгээ, нэгдсэн эрчим хүчний сүлжээ, сансар, далайн гүн, туйлын хайгуулыг чухалчлан хөгжүүлнэ. Үл хөдлөх хөрөнгийн эрхийн тогтолцоог сайжруулах, төсөв, татвар, санхүүгийн системийг шинэчилж өндөр стандартын зах зээлийн тогтолцоог бий болгоно. “Бүс ба зам” санаачилгыг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх замаар өндөр түвшний нээлттэй эдийн

5 Ши Жиньпин "2035 он гэхэд тус улсын эдийн засгийн нийт хэмжээ болон нэг хүнд ногдох дундаж орлогыг хоёр дахин нэмэгдүүлэх бүрэн боломжтой" хэмээсэн.

6 Тус улсын удирдлагууд 2020 оны дундаас “Хос эргэлт” хэмээх шинэ нэр томъёо хэрэглэж эхэлсэн бөгөөд улмаар дунд, урт хугацааны эдийн засгийн хөгжлийнх нь голлох стратеги болж байна.

засгийн хөгжлийг дэмжинэ. Тус санаачилгыг дэмжигч улс орнуудтай стратеги, төлөвлөгөө, механизм, дүрэм, стандартаа уялдуулах замаар хөгжүүлэх, ногоон, агаарын, мөсөн, дижитал, инновацын торгоны зам, орон зайн мэдээллийн коридор зэргийг байгуулна. Тухайлбал, мөсөн торгоны зам нь туйлын эрчим хүчийг ашиглах, тээврийн илүү дөт маршрут бий болгох зорилготой байна.

Үйлдвэрлэлийн бааз, үйлдвэрлэлийн гинжин хэлхээний модернизацийг бий болгоно. Аж үйлдвэрийн хөгжлийг түргэтгэж, бодит эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор цаашид үйлдвэрлэлийн чадавхийн стратеги боловсруулна. Үүнд, газрын ховор элемент, тусгай материал, усан ба нисэх онгоц, өндөр хурдны төмөр замын тоног төхөөрөмж, робот техник, нисэх онгоцны хөдөлгүүр, хиймэл дагуулын системийн хэрэглээний програмууд, шинэ эрчим хүчний тээврийн хэрэгсэл, ухаалаг автомашин, өндөр зэрэглэлийн эмнэлгийн тоног төхөөрөмж, шинэлэг эм, ХАА-н машин механизм гэсэн үндсэн 8 салбар хамаарч байна.

Дижитал Хятад стратеги хэрэгжүүлж, тус салбарын үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн ДНБ-д эзлэх хэмжээг 10%-д хүргэнэ.⁷ Тус стратеги нь тоон технологийн шинэлэг хэрэглээг бэхжүүлэх, үйлдвэржилтийг эрчимжүүлэх, салбарын зах зээлийн дүрмийг

сайжруулж, стандартчилагдсан, цэгцтэй бодлогын орчныг бүрдүүлэх зэрэг зорилтыг багтааж буй.

Газар нутгийн орон зайн төлөвлөлт, хамгаалалт, үйлдвэрлэл, амьдралын ногоон хэвшлийг мэдэгдэхүйц үр дүнд хүргэнэ. Эрчим хүчний нөөцийн тохиргоо, ашиглалтын үр ашиг ихээхэн сайжруулна. Нэгж ДНБ-д ноогдох эрчим хүчний зарцуулалт болон нүүрстөрөгчийн ялгаруулалтыг 2025 он гэхэд тус тус 13.5, 18 хувиар бууруулна.⁸ Ойн бүрхэвч 24.1%-д хүрч, экологийн орчин эрс сайжирна.

Иргэдийн амьжиргааг дээшлүүлэхийн тулд ажлын байрыг нэмэгдүүлэх, дунд орлоготой хэсгийг тэлэх, боловсролын чанарыг сайжруулах, нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэхэд голлон анхаарна. Үүнд, нэг хүнд ногдох орлогын жилийн өсөлтийг ДНБ-ний өсөлттэй уях, 2025 он гэхэд дундаж наслалтыг 1 жилээр нэмэгдүүлэх, хүн амын 95%-ийг хамарсан тэтгэвэрийн даатгалын тогтолцоог хэрэгжүүлэх зэрэг голлох зорилтыг тусгажээ.

Үндэсний аюулгүй байдлыг хангахад эдийн засгийн аюулгүй байдлыг гол түлхүүр хэмээн үзэж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хянах механизм, даван туулах чадавхийг бэхжүүлнэ. Үүнд, хүнс, эрчим хүч, стратегийн ашигт малтмалын хангамжийн аюулгүй байдлыг хангах, санхүүгийн аюулгүй байдлыг сахих, системийн эрсдэлээс урьдчилан

7 2020 оны урьдчилсан тооцоогоор тус улсын дижитал үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн ДНБ-д эзлэх хэмжээ 8 орчим хувь буюу 7.8 их наяд юань болж, Швед, Өмнөд Солонгосын дараа дэлхийд 3-т жагсаж байна.

8 Тус улс 2030 онд нүүрстөрөгчийн ялгаруулалтын дээд түвшинд хүрч, цаашид тогтвортой бууруулан 2060 он гэхэд "нүүрстөрөгчийн нейтрал"-д хүрэхээр зорьж буй. XIV таван жилийн хугацаанд уг зорилтыг биелүүлэх техникийн нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай.

сэргийлэх зэрэг зорилт тусгасан.⁹ Түүнчлэн цэрэг армия бэхжүүлэхэд инновацийн үүргийг онцолж, бэлтгэл сургуулийг бүх талаар бэхжүүлэх, зэвсэг, техник хэрэгслийн шинэчлэлийг түргэтгэх, тус салбарт томоохон төслүүдийг хэрэгжүүлэх замаар батлан хамгаалах болон эдийн засгийн хүч чадлыг хамтад нь сайжруулах ажээ.¹⁰

Шинэ таван жилийн төлөвлөгөөний голлох өөрчлөлтийг дурдвал, үзэл санааны хувьд, “Ши Жиньпиний шинэ эрин”-д Хятадын онцлогтой социализмын үзэл санааг удирдлага, хөгжлийн зарчмын хувьд, “намын цогц удирдлага”-ыг эхний зарчим болгосон, хөгжлийн зорилтын хувьд, “эдийн засгийн хөгжил шинэ амжилтад хүрэх”, “шинэтгэл, нээлттэй байдлын

шинэ алхамууд”, “засаглал шинэ түвшинд гарах” зэрэг олон шинэ томъёолол орсон, үйлдвэрлэлийн гинжин хэлхээ ба хангамжийн сүлжээг орчин үеийн аж үйлдвэрийн системийн гол цөм, технологийн бие даах чадварыг хөгжлийн түлхүүр хүчин зүйл болгох, дотоодын хүчирхэг зах зээл, орчин үеийн төсөв, санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх, шинэтгэлийг гүнзгийрүүлэх тухайд, төрийн өмчийн эдийн засгийг эрс багасгах, дэлхийн жишигт хүрсэн аж ахуйн нэгж (цаашид ААН)-үүдийг бий болгох, шинэ хэлбэрийн хотжилтын хувьд, хүн төвтэй хотжилтыг онцолсон байна (Хүснэгт 1-ийг үзнэ үү).

Хүснэгт 1. Хятадын сүүлийн 3 удаагийн таван жилийн төлөвлөгөөний гол агуулгын харьцуулалт

Голлох чиглэл	XII таван жил (2011-2015)	XIII таван жил (2016-2020)	XIV таван жил (2021-2025)
Гадаад орчин	Дэлхийн санхүүгийн хямралын дараах тогтворгүй үе	Дэлхийн эдийн засаг удаашралтай, худалдааны протекционизм нэмэгдсэн	Геополитикийн өрсөлдөөн хурцдаж, АНУ-Хятадын сөргөлдөөн даамжирсан
Бодлогын чиглэл	Чинээлэг нийгмийг байгуулах, эдийн засгийн хөдөлгөгч хүчийг аж үйлдвэрийн салбараас үйлчилгээний салбарт шилжүүлэх	Чинээлэг нийгмийг бүрэн цогцлоох, зах зээлийг төгөлдөршүүлэх, бүтцийн тэнцвэр	Социалист модернизацийн бүтээн байгуулалтыг бүх талаар эхлүүлж, дараагийн хэтийн зорилт руу чиглэх

9 Тухайлбал, 2025 он гэхэд үр тарианы үйлдвэрлэлийн хүчин чадлыг 650 сая. тн-оос, эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадал (стандарт нүүрс)-ыг 4.6 тэрбум тн-оос багагүй байлгах заавал биелэх зорилт тусгасан.

10 中华人民共和国国民经济和社会发展 第十四个五年规划和2035年远景目标纲要, https://www.ndrc.gov.cn/xxgk/zcfb/ghwb/202103/t20210323_1270124.html, БНХАУ-ын үндэсний эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх XIV таван жилийн төлөвлөгөө ба 2035 оны урт хугацааны зорилтын хөтөлбөр; 李超、孙欧、张迪, 十四五规划详解, 浙商证券研究所, research.stocke.com.cn, Ли Чао нар, XIV таван жилийн төлөвлөгөөний тайлбар

Голлох чиглэл	XII таван жил (2011-2015)	XIII таван жил (2016-2020)	XIV таван жил (2021-2025)
Бодлогын зарчим	ЭЗ-ийн бүтцийн тохируулга, технологийн инноваци, иргэдийн амьжиргааг баталгаажуулах, нөөцийн хэмнэлттэй, байгальд ээлтэй нийгмийг байгуулах, шинэтгэл, нээлттэй байдлыг үргэлжлүүлэх, ШУ болон ЭЗ-ийн хөгжлийн хэлбэрийг өөрчлөх	Иргэд төвт үзэл, шинжлэх ухаанч хөгжил, шинэтгэлийг гүнзгийрүүлэх, хуулиар засаглах, дотоод болон гадаад нөхцөл байдлыг уялдуулах, намын удирдлага	Намын цогц удирдлага, иргэддээ төвлөрөх, шинэ хөгжлийн үзэл баримтлал, шинэтгэл, нээлтийг гүнзгийрүүлэх, системийн сэтгэлгээ; Эдийн засаг, нийгмийн хөгжлийг удирдах намын тогтолцоо
Хөгжлийн үзэл баримтлал	Шинжлэх ухаанч хөгжил	Инноваци, координаци, ногоон хөгжил, нээлттэй байдал, хамтдаа хөгжих	Өмнөх 5 жилийн үзэл баримтлалыг үргэлжлүүлэх
Эдийн засгийн өсөлтийн зорилт	ДНБ жилд дунджаар 7 хувиар өснө	Эдийн засаг дунд өндөр хурдтай өсөлтийг хадгалж, 2020 оны ДНБ 2010 оныхоос 2 дахин өснө	ДНБ-ний жилийн дундаж өсөлтийг зохист хүрээнд барьж, өсөлтийн зорилтыг нөхцөл байдлыг харгалзан жил бүр тогтооно

Эх сурвалж: М.Эрдэнэбаяр, “Хятадын хөгжлийн бодлогын хувьсал, цаашдын чиг хандлага” илтгэл, “Олон улс судлал 2020: Монголын Хятад судлал” ЭШХ; 高長, 中國大陸《十四五規劃》重點及其對兩岸經貿之影響, 展望與探索月刊, 19卷2期 (2021/02/01), P47-65, Гао Жан, “Хятадын XIV таван жилийн төлөвлөгөөний хоёр эргийн худалдаа, эдийн засагт үзүүлэх нөлөө” өгүүлэл

Хоёр. Эдийн засгийн бодлогын өөрчлөлт

1978 оноос явуулсан “шинэтгэл, нээлттэй бодлого”-ын үрээр Хятадын ДНБ 30 гаруй жилийн турш хоёр оронтой тоогоор өсч 2009 онд дэлхийн хоёр дахь том эдийн засаг, 2010 онд дэлхийн хамгийн том экспортлогч болсон. Гэвч тус улсын ДНБ хурдтай өсөхийн хэрээр бүтцийн тэнцвэргүй байдал, орлогын тэгш бус байдал, байгаль орчны бохирдол, нөөцийн хомсдол, хямд, элбэг хөдөлмөрийн хүчний давуу байдлаа алдах зэрэг эдийн засагт үзүүлэх дарамт нэмэгджээ. Улмаар Хятад эдийн засгийн өсөлтийн загвартаа хэд хэдэн удаа тохируулга хийсэн. 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын дараа тус улсын экспортоос

хараат байдлаа бууруулах гэсэн хүчин чармайлтыг “эдийн засгийг тэнцвэржүүлэх стратеги” гэж нэрлэдэг. 2014 оноос үргэлжлүүлэн “шинэ хэвшил” буюу эдийн засгийн бүтцийн шинэчлэл хийх, нийт эдийн засагт үйлчилгээний салбарын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх бодлого явуулж байна. Харин XIV таван жилийн төлөвлөгөөний хугацаанд хос эргэлт, технологийн бие даалт, үйлдвэрлэлийн хамгамжийн сүлжээг бэхжүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зэрэг голлох стратеги хэрэгжүүлэх бөгөөд “хос эргэлт стратеги” эдийн засгийн хөгжлийн үндсэн хөдөлгөх хүч болж, ирээдүйн чиглэлийг тодорхойлно хэмээн тайлбарлаж байна.

Уг стратегийн гол зорилго нь экспорт болон хөрөнгө оруулалтад суурилсан өсөлтийн бодлогоо өөрчилж, дотоодын хэрэглээнд тулгуурлан эдийн засгийн бүтцийн шилжилтээ үргэлжлүүлэх, тодруулбал, асар том дотоод зах зээлийн давуу талдаа найдах, үйлдвэрлэл, хэрэглээ, эргэлт, хуваарилалт дахь саадыг арилгах, дотоод эрэлтийн цогц системийг бий болгох, дотоод болон гадаад эргэлт бие биенээ дэмжсэн эдийн засгийн хөгжлийн шинэ хэв маягыг бүрдүүлэх аж.¹¹ Дотоод эргэлтийн хувьд, дотоод эрэлтийн тэлэлтийг стратегийн суурь цэг болгон авч, дотоодын хэрэглээний тогтолцоог

иж бүрэн болгох, инновацлаг өндөр чанартай нийлүүлэлтээр шинэ эрэлтийг бий болгох, хэрэглээг бүх талаар дэмжиж, хөрөнгө оруулалтын орон зайг өргөжүүлэх зэрэг голлох бодлого хэрэгжүүлнэ. Гадаад эргэлтийн хувьд, нээлттэй байдал, зах зээлийн хүртээмж, худалдааны зохион байгуулалтыг сайжруулах зэргээр олон улсын зах зээлийг улам бүр нээх, үүнд, тус улсын “Бүс ба зам” санаачилга томоохон үүрэг гүйцэтгэнэ (Хүснэгт 2-ыг үзнэ үү). Зах зээлийн хүртээмжийг өргөжүүлэх тухайд, гадагш нээлттэй байдал, гадаадын хөрөнгө оруулалт (ГХО)-ыг нэмэгдүүлж, монополийг багасгах, өрсөлдөөнийг төгөлдөршүүлэх, үүнд, ГХО-ын сөрөг жагсаалтыг эрс багасгах, үйлчилгээ, үйлдвэрлэл, ХАА-н салбар дахь нээлттэй байдлыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ хэрэгжүүлнэ. Түүнчлэн шинэ таван жилийн төлөвлөгөөний бас нэг чухал үйл ажиллагаа нь төрийн өмчит үйлдвэрийн газар (цаашид ТӨҮГ)-уудын шинэчлэлийн асуудал бөгөөд төрийн үйлчилгээнд хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, өөрөөр хэлбэл, төр хувийн хэвшлийн холимог бүтцийг бий болгож, ТӨҮГ-уудын менежмент, өрсөлдөх чадварыг сайжруулах зорилготой байна.¹²

11 What does China's dual circulation strategy mean?, 14 December 2020, <https://focus.cbbc.org/what-does-chinas-dual-circulation-strategy-mean/#.YCDcxLazbIU>, 王國臣, 中國大陸經濟雙循環戰略之觀察, 2020. 10. 15, <https://www.sef.org.tw/article-1-129-10816>, Ван Гуочэн, Хятадын эдийн засгийн Хос эргэлт стратеги

12 高長, 中國大陸《十四五規劃》重點及其對兩岸經貿之影響, 展望與探索月刊, 19卷 2 (2021/02/01), P47-65, <https://www.airitilibrary.com/Publication/alDetailedMesh?docid=P20200116001-202102-202102220005-202102220005-47-65>

Хүснэгт 2. Хос эргэлт стратегийн гол агуулга

	Гол агуулга	
Дотоод эргэлт	Үйлдвэрлэл	<p>Сул талаа нөхөх: Уламжлалт үйлдвэрлэлийн бүтцийг оновчтой болгох, шинээр гарч ирж буй салбаруудад технологийн хараат бус байдлыг бэхжүүлэх</p> <p>Давуу талаа бэхжүүлэх: Аж үйлдвэрийн аварга сүлжээний давуу талаа ашиглаж, орчин үеийн үйлдвэрлэлийн гинжин хэлхээг бий болгох</p>
	Хэрэглээ	<p>Шинэ хэлбэрийн хотжилт, өрхийн бүртгэлийн системийн шинэчлэл; Дотоод эрэлтийг өргөжүүлж, хэрэглээг дэмжих;</p> <p>Инноваци, өндөр чанартай нийлүүлэлтээр шинэ эрэлт бий болгох; Өндөр орлоготой хэсгийн хэрэглээг татваргүй дэлгүүрээр дамжуулах замаар дотооддоо үлдээх;</p> <p>Орон сууцны хэт их хэмжээний зээл хэрэглээнд сөргөөр нөлөөлж буйг багасгах;</p> <p>Бага орлоготой хэсгийн санхүүгийн шилжүүлгийн төлбөр ба төрийн үйлчилгээний баталгааг нэмэгдүүлэх.</p>
	Эргэлт	<p>Газар, ажиллах хүч, хөрөнгө, технологи, өгөгдөл зэрэг хүчин зүйлийн зах зээлжих шинэчлэлийг урагшлуулах.</p> <p>Өндөр стандартын зах зээлийн тогтолцоо, шударга өрсөлдөөний орчныг бүрэн бий болгох.</p>
	Хуваарилалт	<p>Баян, ядуугийн ялгааг багасгах: Хөдөлмөрийн хөлсний хэмжээг нэмэгдүүлэх, орон сууцны хөрөнгө оруулалтын бус амьдран суух зорилгыг чухалчлах, төсвийн болон татварын шинэчлэл, хот хөдөө дэх нөөцийн хуваарилалтыг сайжруулах.</p>
Гадаад эргэлт	Интеграци	<p>Зах зээлийн хүртээмжийг өргөжүүлэх, ялангуяа үйлчилгээний салбарт;</p> <p>Юанийн олон улсжих орчныг бүрдүүлэх.</p>
	Худалдааны зохион байгуулалт	<p>“Бүс ба зам” санаачилгыг өргөжүүлэн хөгжүүлж, улс орнуудын зах зээлийг улам бүр нээх;</p> <p>Хайнаньд чөлөөт худалдааны боомт байгуулж, эдийн засгийн нээлттэй байдлыг өргөжүүлэх;</p> <p>Олон талт болон хоёр талын бүс нутгийн худалдааг нэмэгдүүлэх.</p>

Эх сурвалж: 高長, 中國大陸《十四五規劃》重點及其對兩岸經貿之影響, 展望與探索月刊, 19卷2期 (2021/02/01), P47-65; Гао Жан, “Хятадын XIV таван жилийн төлөвлөгөөний хоёр эргийн худалдаа, эдийн засагт үзүүлэх нөлөө” өгүүлэл

Хос эргэлт стратегийг нэг талаас, бусад аж үйлдвэржсэн улсын, ялангуяа ХХ зууны эхэн үеийн АНУ-ын адил эдийн засгийн хөгжлийн дараагийн логик алхам, нөгөө талаас, гадаад орчны өөрчлөлтийг тооцож энэ цаг үед хэрэгжүүлэх шаардлага үүсжээ гэж үзэж болхоор байна. Тодруулбал, АНУ-ын эдийн засгийн хөгжил 3 үе шатыг дамжсан. Эхний үе шат (1800-1870)-нд эдийн засаг хоцрогдсон, ХАА, түүхий эдийн экспортод түшиглэж, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг импортоор хангаж байв. Энэ үе шатанд дотоод зах зээл, гадаад худалдаа хөгжөөгүй, гадаад орцоос ихээхэн хамааралтай байдаг ба хямд экспорт өндөр үнэтэй импорттой хосолсноор худалдааны алдагдал ихэсдэг. Хоёр дахь үе шат бол аж үйлдвэрийн хувьсгалын эрин үе (1870-1913), энэ үед ихэвчлэн гадаад зах зээлд зориулсан өргөн хэрэглээний хямд бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрс нэмэгдэж, улмаар гадаад зах зээлийн эрэлтийг өдөөж гадаад худалдаанд

илүүдэл үүссэн. Гурав дахь үе шат (1913-одоог хүртэл)-нд дотоодын цалин хөлс өсөж, хэрэглэгчид дотоодын болон олон улсын аль аль бүтээгдэхүүн, үйлчилгээг авч чадах хангалттай мөнгөтэй болсон. АНУ дэлхийн нэгдүгээр дайн эхлэхэд энэ үе шатанд хүрсэн бол Хятад 2020 оноос орж байна. Энэ үеийн үндсэн шинж чанар нь нийт хэрэглээнд хүнс, хувцас зэрэг өргөн хэрэглээний барааны эрэлт харьцангуй буурч, зугаа цэнгэл, аялал жуулчлал, орон сууцанд зарцуулах зардал өсдөг.¹³

Дүгнэвэл, Хятадын шинэ таван жилийн төлөвлөгөөний голлох стратегиуд барууны өндөр хөгжсөн улсуудын эдийн засгийн хөгжлийн түүхэн замналын нэгэн адилаар тус улсын эдийн засгийг хүчин зүйл, хөрөнгө оруулалтад суурилсан хөгжлийн үе шатнаас дараагийн үе шат буюу инноваци, эд баялагт суурилсан хөгжлийн үе шат руу шилжилт хийхэд чиглэж байна.

13 程实、王宇哲、钱智俊、高欣弘，‘双循环的演进之路：2020与1913——中国经济双循环格局研究系列之三’，<http://www.icbc.com.cn>，Чэн Ши нар, 2020 ба 1913 - Хятадын эдийн засгийн Хос эргэлт хэв маягийн талаар хийсэн гурав дахь цуврал судалгаа

Гурав. Сорилт ба боломж

Хятадын судлаач Чэн Ши нар шинэ коронавирусын мутаци дараагийн тархалтыг үүсгэх, Хятад, АНУ-ын сөргөлдөөний гэнэтийн өөрчлөлтүүд XIV таван жилийн төлөвлөгөөний голлох сорилт байна хэмээн үзэж буй¹⁴ бол АНУ-ын судлаач Миншин Пэй, уг төлөвлөгөөнд тусгасан үндэсний аюулгүй байдалд онцгой анхаарал хандуулхаас бусад ихэнх бодлого нь шинэ зүйл биш бөгөөд бодлогуудын хооронд багагүй зөрчил байгааг анхааруулжээ. Үүнээс аюулгүй байдлаа нэмэгдүүлэхийн зэрэгцээ нээлттэй байдлыг хадгалахад гол зөрчил үүсэх аж. Учир нь эдийн засгийг интеграцчиллаас аюулгүй байдал руу чиглүүлэх нь үр ашиг ихээхэн алдахад хүргэнэ, тухайлбал, хамгийн үр ашигтай, өндөр технологитой үйлдвэрлэгчидтэй харилцаагаа таслах эсвэл хязгаарлахад хүргэж, харьцангуй хөгжил сул салбарууддаа нөөцөө оруулах шаардлагатай болно.¹⁵

Харин хос эргэлт буюу дотоод зах зээлээ илүү түших бодлогод тус улсын өрхүүдийн орлогыг нэмэгдүүлэх асуудал гол сорилт болж байна.¹⁶ Дотоод эрэлтийг өсгөхийн тулд баялгийг фирмүүд болон хөрөнгө

оруулагчдаас өрхүүдэд өндөр цалин эсвэл нийгмийн халамжаар дамжуулан шилжүүлэх шаардлагатай байдаг. Гэвч өндөр цалинтай болсноор хөдөлмөрийн өртөг өсөж Хятадын үйлдвэрлэгчдийн олон улс дахь өрсөлдөх чадвар сулрана. Мөн ажиллах хүчний бууралт, нөөц ашиглалтын үр өгөөж тааруу, төрийн өмчит ААН-үүд инновацийн эрэлтэд хүрэхэд хол зэрэг хүчин зүйл дотоод эрэлтийг нэмэгдүүлэхэд тийм ч амар байхгүйг харуулж буй. Түүнчлэн хүн амын хөгшрөлтөөс үүдэж эрүүл мэнд, тэтгэвэр тэтгэмжид зарцуулах хөрөнгө хурдацтай өснө. Эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, технологиор хүчирхэгжих, хүнс, эрчим хүчний стратегийн нөөцийг бүрдүүлэх зэрэгт асар их хөрөнгө шаардагдана.¹⁷

Гэхдээ Хятадын асар том хэрэглээний зах зээл дотоод эргэлтийн бодлогод давуу тал болно. 2019 онд тус улсын эцсийн хэрэглээ 6.4 их наяд ам.доллар болж ДНБ-ний 57.8%-ийг эзэлсэн бол бусад өндөр орлоготой 40 орны эдийн засагт эзлэх эцсийн хэрэглээ дунджаар 70.4% байна. Үүнээс цаашид дотоод эрэлтийг өсгөх, үйлчилгээний зах зээлийг нэмэгдүүлэх томоохон нөөц боломж байгаа нь

14 李超、孙欧、张迪，十四五规划详解，浙商证券研究所，research.stocke.com.cn

15 Minxin Pei, Threading the Needle: Balancing Security and Development in the 14th Five-Year Plan China, Summer 2021 Issue 68 Tuesday, June 1, 2021, <https://www.prcleader.org/mpei>

16 Хятадын нэг хүнд ногдох ДНБ 10216 ам.доллар байгаа нь Японы 40246, АНУ-ын 65297 ам.доллартай (Дэлхийн банк, 2019 он) харьцуулахад маш бага. Түүнчлэн 2020 оны 1 дүгээр улиралд тус улсын өрхүүдийн өр ДНБ-ний 57.2%-ийг эзэлж, 2006 оны 1 дүгээр улирлаас 45.7 пунктээр өсчээ. ОУВС 2024 он гэхэд Хятадын өрхүүдийн өрийн харьцаа Япон, Евро бүсийнхээс давна гэж таамагласан. 王國臣，‘國大陸經濟雙循環戰略之觀察’，2020. 10. 15, <https://www.sef.org.tw/article-1-129-10816>

17 Minxin Pei, Threading the Needle: Balancing Security and Development in the 14th Five-Year Plan China, Summer 2021 Issue 68 Tuesday, June 1, 2021, <https://www.prcleader.org/mpei>

харагдаж байна. Түүнчлэн тус улсын хотжилтын түвшин (2020 онд 61%-д хүрсэн) болон тээврийн сүлжээний хөгжил харьцангуй сайн байгаа нь цаашид дотоод зах зээлийн өсөлтийг дэмжих чухал хүчин зүйл юм.

Гадаад голлох сорилт нь Хятадын АНУ-тай хийж буй стратегийн өрсөлдөөн бөгөөд барууны улсууд, ялангуяа АНУ Хятадтай “эдийн засгийн тусгаарлах” бодлого явуулж буй. Барууны хөгжингүй орнууд Хятадын эсрэг нэгдэх, өндөр технологи, мэдлэгт суурилсан шинэ үйлдвэрлэлийн хөгжлийг анхаарах, боловсруулах аж үйлдвэрүүдээ буцаан татах зэрэг бодлого барих нь Хятадын гадаадын капиталыг ашиглах боломжийг бууруулж, улмаар тус улс руу чиглэх дунд, өндөр зэрэглэлийн үйлдвэрлэлийн шилжилт удааширна. Цаашид цар тахлын нөлөөгөөр үйлдвэрлэлийн нийлүүлэлтийн сүлжээ аажмаар бүс нутгийн шинжтэй болж, богино гинжин хэлхээ зонхилох магадлалтай ба энэ байдал Хятадын боловсруулах үйлдвэрлэлийн шинэчлэлийг хязгаарлана.¹⁸

Гэхдээ Хятад дэлхийн бусад зах зээлд нөлөөгөө тэлсээр байна, тухайлбал, 2020 оны 11 дүгээр сард Хятад бусад 14 улстай Бүс нутгийн

эдийн засгийн цогц түншлэл (RCEP)-д гарын үсэг зурж Ази, Номхон далайн бүс нутаг дахь харилцаа холбоогоо бэхжүүллээ. Азийн хөршүүдтэйгээ идэвхтэй харилцсаны үр дүнд 2020 оны эхний хагаст АСЕАН Европын холбоог давж Хятадын хамгийн том худалдааны түнш болсон бол 2021 онд БНХАУ, Европын холбооны хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурах, БНХАУ, Япон, БНСУ-ын чөлөөт худалдааны хэлэлцээрийн явцыг түргэтгэх, Номхон далайг дамнасан иж бүрэн, дэвшилтэт түншлэлийн хэлэлцээр (СРТРРА)-т нэгдэх талаар нухацтай авч үзэх ажээ.¹⁹

Цаашид шинэ төлөвлөгөө, стратегийг амжилттай хэрэгжүүлэхэд даяаршил, шинээр үүсэж буй зах зээлийг дэмжих, сөрөг жагсаалтыг хэрэгжүүлж, өндөр чанартай гадаадын компаниудыг дотоодын зах зээлд нэвтрүүлэх, дотоодын ААН-үүдийг аль болох олон улсад гаргах, тэдний аюулгүй байдлыг хангах, дотоодын түүхий эдийн фьючерс зах зээлийг олон улсын түвшинд гаргах, дотоодын болон олон улсын зах зээл дээрх түүхий эдийн хангамжийн давуу талуудыг бүрэн ашиглах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай хэмээн Хятадын зарим судлаач анхааруулжээ.²⁰

18 高長，中國大陸《十四五規劃》重點及其對兩岸經貿之影響，展望與探索月刊，19卷2 (2021/02/01)，P47-65，<https://www.airitilibrary.com/Publication/alDetailedMesh?docid=P20200116001-202102-202102220005-202102220005-47-65>

19 BBC，中国两会李克强政府工作报告看点：经济增长目标、香港选举制度、国防预算，<https://www.bbc.com/zhongwen/simp/world-56289591>；BBC，Хятадын Хоёр чуулган ба засгийн газрын ажлын тайлан：Эдийн засгийн өсөлтийн зорилго，Хонконгийн сонгуулийн систем，батлан хамгаалахын төсөв

20 甄新伟、任绍敏，从五个维度深刻理解“双循环”战略内涵，2020-08-19，<https://www.yicai.com/news/100740860.html>；Жэн Синвэй，Рен Шаомин，Таван хэмжигдэхүүнээс хос эргэлт стратегийн утгыг гүнзгий ойлгох нь

Дөрөв. Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөө

Монгол Улс гадаад худалдааны хувьд урд хөршөөсөө ихээхэн хамааралтай байгаа²¹ тул тус улсын хөгжлийн төлөвлөгөө, эдийн засгийн бодлогын өөрчлөлт манай улсын эдийн засагт шууд болон дам нөлөө үзүүлнэ. Том зургаар харвал, Хятад эдийн засгийн нийт хэмжээ болон нэг хүнд ногдох дундаж орлогоо 2035 он гэхэд хоёр дахин нэмэгдүүлэх, технологийн хүчирхэг улс болох зорилт тавьж буй нь тус улсын эдийн засгийн “татах хүч”-ийг улам нэмэх, нэг талаас ашиглаж чадвал томоохон боломж, нөгөө талаас санхүү, үйлдвэрлэл, технологийн хараат байдалд орох, ажиллах хүчнээ алдах зэрэг сорилт нэмэгдэнэ.

Худалдаа, эдийн засгийн боломжийн хувьд, Хятад хос эргэлт стратегийг хэрэгжүүлснээр дотоод зах зээл, хэрэглээ нь улам томрох бөгөөд тэр хэрээр бусад улсаас нөөцийн хязгаарлагдмал байдлаа нөхөх, ялангуяа эрчим хүч, хүнсний нөөцийг дэд бүтэц, чанар, стандартын давуу талтай орнуудаас хангана. Манай улс хөрш байрлалын давуу талаа бүрэн

ашиглах, эрдэс баялагийн экспортын нийлүүлэлтийн сүлжээний чадавхиа сайжруулах, нэмүү өртөг шингээх бодлогоо хурдтай хэрэгжүүлэх, бусад өрсөлдөх чадвар бүхий ХАА, аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний салбарт хангалттай бизнесийн эрх чөлөө олгох, хөгжлийн үе шатанд нь тохирсон стандарт нэвтрүүлэх замаар тууштай хөгжүүлэх шаардлагатай.

Харин Хятадын инновациар өртөг шингээх, биеэ даах, эдийн засгийн аюулгүй байдлаа хангах бодлого тус улсаас импортлох бараа бүтээгдэхүүний үнэ өртөгийг нэмэгдүүлэх магадлалтай. Иймээс өөрийн үйлдвэрлэлийг аль болох төрөлжүүлж хөгжүүлэх, мөн худалдааг хөнгөвчлөх гэрээ хэлэлцээр байгуулах, логистикийн дэд бүтцийг цогцоор бий болгох, төрийн албаны хүнд суртал, авилгыг таслан зогсоох зэрэг бизнес эрхлэлтийн саад тотгорыг арилгахад онцгой анхаарах хэрэгтэй байна. Цаашид тус улсын төлөвлөгөө, стратегийг нарийвчлан судлаж, эдийн засгийн хөгжлийн бодлого, стратегидаа уялдуулах нь зүйтэй болов уу.

21 2020 оны байдлаар нийт экспортын 72.5, импортын 35.7 хувийг Хятад улс дангаараа эзэлж байна. <https://customs.gov.mn/>

Дүгнэлт

БНХАУ 2035 он гэхэд модернизацийг, 2050 оны орчим орчин үеийн хүчирхэг улсыг бүрэн бий болгохыг зорьж, шинэ таван жилийн төлөвлөгөө (2021-2025) нь уг үйл ажиллагааг эхлүүлж байна. Эдийн засгийн хөгжлийн үндсэн стратеги нь “хос эргэлт” бөгөөд товчдоо, эдийн засгийн өндөр өсөлтийг бий болгосон экспорт, гадаадын хөрөнгө оруулалтыг хадгалахын сацуу, импортыг орлох бодлогоор импортыг бууруулах, чанаржуулах явдал ажээ. Бүтцийн шилжилт, нийлүүлэлтийн шинэчлэл, “Бүс ба зам” санаачилга зэрэг эдийн засгийн бодлогын ерөнхий чиглэл нь хэвээр байж, цаашид илүү өргөн хүрээгээр тогтвортой хэрэгжүүлнэ. Өндөр стандартын зах зээлийн тогтолцоог бүрдүүлэх, өөрөөр хэлбэл, чөлөөт зах зээлийн тогтолцоо, эдийн засгийн эрх чөлөөг хөгжлийн гол хөдөлгөгч хүч хэмээн үзэж байна.

Үндэсний эдийн засгаа цар тахал, геополитикийн сөргөлдөөнт

орчин зэрэг гадаад хүчин зүйлд тэсвэртэй болгоход онцгой анхаарч, технологиор хүчирхэг болох зорилт тавьж, АНУ болон бусад улстай ширүүн өрсөлдөөнд орж байна. Энэ нь инновац, судалгаа шинжилгээ, өндөр технологид хөрөнгө, хүч хаяна гэсэн үг. Уг стратеги Хятадад өндөр технологийн бүтээгдэхүүн экспортлогчдод сөрөг нөлөө үзүүлнэ.

Хятад шинэ төлөвлөгөө, стратегиа амжилттай хэрэгжүүлж чадах эсэхийг хэлэхэд эрт байна, учир нь гадаад орчин нь таатай бус болж, үйлдвэрлэлийн инновацийн чадвар хязгаарлагдмал, өндөр технологийн хувьд гадаад улсуудаас ихээхэн хараат зэрэг сорилт, бэрхшээл багагүй байна. Гэхдээ тус улс өндөр хөгжсөн улсуудын эдийн засгийн хөгжлийн түүх, онол, сургаалиас суралцаж, үндсэндээ адил арга замаар эдийн засгаа хөгжүүлж байна, өөрөөр хэлбэл, тодорхой амжилт гаргах магадлал өндөр юм.

Ашигласан материал:

1. 2021年政府工作报告, http://www.gov.cn/premier/2021-03/12/content_5592671.htm; БНХАУ-ын Засгийн газрын ажлын тайлан 2021
2. 中华人民共和国国民经济和社会发展第十四个五年规划和2035年远景目标纲要, https://www.ndrc.gov.cn/xxgk/zcfb/ghwb/202103/t20210323_1270124.html; БНХАУ-ын үндэсний эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх XIV таван жилийн төлөвлөгөө ба 2035 оны урт хугацааны зорилтын хөтөлбөр
3. What does China's dual circulation strategy mean?, 14 December 2020, <https://focus.cbbc.org/what-does-chinas-dual-circulation-strategy-mean/#.YCDcxLAzbIU>;
4. 王國臣, 中國大陸經濟雙循環戰略之觀察, 2020. 10. 15, <https://www.sef.org.tw/article-1-129-10816>; Ван Гуочэн, Хятадын эдийн засгийн Хос эргэлт стратеги
5. An analysis of china's 14th five-year plan, <https://www.msadvisory.com/news-updates/march-2021/an-analysis-of-china-14th-five-year-plan>
6. 李超、孙欧、张迪, 十四五规划详解, 浙商证券研究所, research.stocke.com.cn; Ли Чао нар, XIV таван жилийн төлөвлөгөөний тайлбар
7. 高長, 中國大陸《十四五規劃》重點及其對兩岸經貿之影響, 展望與探索月刊, 19卷2期 (2021/02/01), P47-65, <https://www.airitilibrary.com/Publication/aiDetailedMesh?docid=P20200116001-202102-202102220005-202102220005-47-65>; Гао Жан, “Хятадын 14-р таван жилийн төлөвлөгөөний хоёр эргийн худалдаа, эдийн засагт үзүүлэх нөлөө” өгүүлэл
8. 程实、王宇哲、钱智俊、高欣弘, ‘双循环的演进之路: 2020与1913——中国经济双循环格局研究系列之三’, <http://www.icbc.com.cn>; Чэн Ши нар, 2020 ба 1913 он-Хятадын эдийн засгийн хос эргэлт хэв маягийн талаар хийсэн 3 дахь цуврал судалгаа
9. Minxin Pei, Threading the Needle: Balancing Security and Development in the 14th Five-Year Plan China, Summer 2021 Issue 68 Tuesday, June 1, 2021, <https://www.prcleader.org/mpei>
10. BBC, 中国两会李克强政府工作报告看点: 经济增长目标、香港选举制度、国防预算, <https://www.bbc.com/zhongwen/simp/world-56289591>; BBC, Хятадын “хоёр чуулган” ба засгийн газрын ажлын тайлан: эдийн засгийн өсөлтийн зорилго, Хонконгийн сонгуулийн систем, батлан хамгаалахын төсөв
11. 甄新伟、任绍敏, 从五个维度深刻理解“双循环”战略内涵, 2020-08-19, <https://www.yicai.com/news/100740860.html>; Жэн Синвэй, Рен Шаомин, Таван хэмжигдэхүүнээс хос эргэлт стратегийн утгыг гүнзгий ойлгох нь
12. М.Эрдэнэбаяр, “Хятадын хөгжлийн бодлогын хувьсал, цаашдын чиг хандлага” илтгэл, “Олон улс судлал 2020: Монголын Хятад судлал” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл
13. Монгол Улсын Гаалийн статистик мэдээ, <https://customs.gov.mn/>

China's new five year plan and its economic policy changes

Erdenebayar Munkhuu

*Ph.D, Institute of International Affairs,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia
erdenebayar_m@mas.ac.mn*

Abstract: *In accordance with longstanding tradition, China approved its 14th Five-Year National Plan for Economic and Social Development in 2021-2025 in March this year. The national plan emphasizes innovation, production, technology, and security, and sets a long-term goal for 2035. The key to the successful implementation of the national plan is to expand its domestic demand, which will be the main driver of economic growth in the future. However, there are several challenges China may face in implementing its national plan such as insufficient incomes of households, ineffective use of resource, global pandemic and China-U.S. rivalry. The first part of the article outlines the main objectives, strategies, and characteristics of China's new five-year national plan, the second part analyzes the changes in the country's economic development policy, and the third part discusses the challenges and feasibility of the plan. In the final part, the author shares his views on the potential implications of China's new national plan on the Mongolian economy and the issues to be addressed.*

Keywords: *14th Five-Year National Plan, Dual Circulation Strategy, Challenges and Opportunities*

The day of submission: 2021.06.18
Completion of review: 2021.06.24
Final decision for acceptance: 2021.07.09